ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Алдархаан сумын Ерөнхий боловролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ЗАА-2025/116/НА-СТА-ТШЗ

---


Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК -гэрээт аудитор: Б.Цэрэндэжид

Утас: 99812811

Цахим хаяг: tserendejid1109@gmail.com

Цахим хуудас: www.audit.mn


Улиастай сум

2025 он

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА


1. Хараат бус аудиторын дүгнэлт 3

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 4

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 4

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 5

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 7

3. Санхүүгийн тайлангийн тодруулга........8

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 8

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 10

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 10

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт 11

4. Аудитын тайлан........13

4.1 Ерөнхий зүйл........13

4.2 Материаллаг байдал........14

4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт........14

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал........14

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт........15

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал........16

5. Аудитын илрүүлэлт........16

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл


---

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.02.21 № 182

танай ____________-ны № ____________-т

АЛДАРХААН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ц.НАНДИНЦЭЦЭГ-Т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алдархаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алдархаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Алдархаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны гүйцэтгэлийн үнэлгээнд 14 багш хамрагдсанаас II индексээр 2 багш, III индексээр 2 багш, IV индексээр 3 багш үнэлэгдэж, байгууллагын үнэлгээгээр IV түвшинд үнэлэгдсэн байна. 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 33 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилт 92.0 хувьтай дүгнэгджээ.

Алдархаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2024 онд улсын төсвөөс 914,409.1 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 114,173.6 мянган төгрөгийн санхүүжилттэй ажиллаж 77,899.0 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй ажилласан байна.

**Аудитын гол асуудал**

Алдархаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 157 нэр төрлийн 126,389.2 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгийг дахин үнэлж, ашиглах хугацааг сунгаагүй, 2,987.5 мянган төгрөгийн зардлыг эдийн засгийн ангиллаар зарцуулаагүй, дотуур байрны хүүхдийн хоолыг нормативт зардлаас 855.5 мянган төгрөгөөр дутуу, үдийн хоолны зардлыг нормативт зардлаас 659.4 мянган төгрөгөөр илүү, хүнсний

материалын үлдэгдэл 2,523.1 мянган төгрөгөөр дутагдсан, цалингийн зардлаас шагналын дагалдах мөнгөн урамшуулал 1,700.0 мянган төгрөгийг тус тус олгосон байна.

**Бусад асуудлын хэсэг**

Алдархаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь төсвийн хөрөнгөөр 24,618.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авч, Боловсролын ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар 19,016.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Олон улсын энэрлийн байгууллагаа 15,819.8 мянган төгрөгийн зөөврийн компьютер, 1,148.7 мянган төгрөгийн ном, 900.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэнийг данс бүртгэлд тусгасан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-ҮНДРАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Õóààõàà: 24.12.31

| Данс | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 158,732,164.56 | 200,644,351.82 |
| 31 | МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ | 36,244,601.76 | 77,899,073.99 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 36,244,601.76 | 77,899,073.99 |
| 3121 | Төгрөг | 36,244,601.76 | 77,899,073.99 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 36,244,601.76 | 77,899,073.99 |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | 0.00 | - |
| 33 | АВЛАГА | - | 1,654,847.23 |
| 33100 | Ажиллагсадтай холбогдсон авлага | - | 1,654,847.23 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 122,487,562.80 | 121,090,430.60 |
| 351 | Түүхий эд материал | 140,000.00 | 140,000.00 |
| 35130 | Эм боох материал | 140,000.00 | 140,000.00 |
| 354 | Хангамжийн материал | 122,347,562.80 | 120,950,430.60 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,088,000.00 | 1,440,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,146,040.00 | 2,657,650.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 4,037,000.00 | 3,362,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 21,402,360.00 | 15,809,270.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 93,674,162.80 | 97,681,510.60 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 869,454,649.72 | 948,639,467.01 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 869,454,649.72 | 948,639,467.01 |
| 392 | Биет хөрөнгө | 820,265,649.72 | 899,780,467.01 |
| 39201 | Барилга, байгууламж | 848,145,555.00 | 848,145,555.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (186,201,779.64) | (203,277,480.30) |
| 39203 | Авто тээврийн хэрэгсэл | 1,335,000.00 | 1,335,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (1,335,000.00) | (1,335,000.00) |
| 39205 | Машин, тоног төхөөрөмж | 201,893,404.00 | 336,402,294.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (114,108,421.08) | (153,409,640.86) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 103,823,397.82 | 106,129,287.82 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (52,599,474.80) | (54,710,809.37) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 3,551,943.00 | 3,551,943.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (2,133,144.18) | (2,258,559.78) |
| 39217 | Номын фонд | 17,894,169.60 | 19,207,877.50 |
| 393 | Биет бус хөрөнгө | 49,189,000.00 | 48,859,000.00 |
| 39301 | Програм хангамж | 2,600,000.00 | 2,600,000.00 |
| 39302 | Хасагдуулга | (2,105,000.00) | (2,435,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 48,694,000.00 | 48,694,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 1,028,186,814.28 | 1,149,283,818.83 |
| 413 | Өглөг | 50,172,021.65 | 116,579,409.77 |
| 41310 | Ажиллагчидтай холбогдсон өглөг | - | (0.00) |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 49,926,561.65 | 41,050,309.77 |
| 4136 | Бусад өглөг | 245,460.00 | 75,529,100.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 245,460.00 | 75,529,100.00 |
| 41364 | НДШ өглөг /ТӨҮГ/ | 0.00 | 0.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 978,014,792.63 | 1,032,704,409.07 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 978,014,792.63 | 1,032,704,409.07 |

| | | | |
|---|---|---|---|
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан | 445,813,001.30 | 445,813,001.30 |
| 51101 | Өмч: -Төрийн өмч | 445,813,001.30 | 445,813,001.30 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 317,529,554.56 | 373,051,515.00 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 317,529,554.56 | 318,361,898.56 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 54,689,616.44 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 214,672,236.77 | 213,839,892.77 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 1,028,186,814.28 | 1,149,283,818.83 |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Õóãàõàà: 24.12.31

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 829,975,646.26 | 1,077,006,645.70 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 65,214,546.26 | 48,423,945.70 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 65,214,546.26 | 48,423,945.70 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 65,214,546.26 | 2,857,347.80 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 293,000.00 | 520,000.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын орлого | 64,921,546.26 | 2,337,347.80 |
| 120017 | Үнэ төлбөргүй авсан үндсэн хөрөнгө | - | 45,566,597.90 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 764,761,100.00 | 1,028,582,700.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 660,198,700.00 | 914,409,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 660,198,700.00 | 914,409,100.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 104,562,400.00 | 114,173,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 104,562,400.00 | 114,173,600.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II) | 788,024,087.10 | 1,022,317,029.26 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 788,024,087.10 | 1,022,317,029.26 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 785,883,987.10 | 1,021,069,029.26 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 493,173,683.00 | 698,396,093.73 |
| 210101 | Цалин | 255,012,115.00 | 423,850,727.73 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 218,106,426.00 | 231,288,816.00 |
| 210104 | Урамшуулал | 20,055,142.00 | 43,256,550.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 60,447,253.18 | 87,759,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 41,454,160.80 | 60,999,199.65 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 4,916,737.28 | 7,085,446.26 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 3,933,389.82 | 5,511,251.87 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 922,087.93 | 1,390,744.24 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 9,220,877.34 | 12,772,757.98 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 106,310,586.18 | 101,297,348.12 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 6,711,518.18 | 6,807,658.17 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 99,599,068.00 | 94,489,689.95 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 6,222,940.00 | 15,769,250.00 |
| 210401 | Бичиг хэргийн материал | 2,378,640.00 | 2,067,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахууны зардал | 870,000.00 | 2,085,700.00 |
| 210406 | Бага үнэ түргэн элэгдэл зүйлс | 2,974,300.00 | 11,616,550.00 |
| 2105 | Нормативт зардал | 37,909,290.00 | 39,433,537.00 |
| 210501 | Эм | 269,050.00 | - |
| 210502 | Хоол | 37,640,240.00 | 39,433,537.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 12,786,630.00 | 4,922,970.00 |
| 210604 | Урсгал засвар | 12,786,630.00 | 4,922,970.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2107 | Томилолт, зочны зардал | 308,000.00 | - |
| 210702 | Дотоод томилолтын зардал | 308,000.00 | - |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 3,198,000.00 | 1,689,759.50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 175,000.00 | 520,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 1,296,000.00 | - |
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс | 1,727,000.00 | 1,169,759.50 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 65,527,604.74 | 71,800,670.91 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,773,400.00 | 5,202,890.30 |
| 210902 | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | - | 160,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 60,754,204.74 | 66,437,780.61 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,140,100.00 | 1,248,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 2,140,100.00 | 1,248,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 2,140,100.00 | 1,248,000.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II) | 41,951,559.16 | 54,689,616.44 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI) | 41,951,559.16 | 54,689,616.44 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Õóãàöàà: 24.12.31

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 765,054,100.00 | 1,029,102,700.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 293,000.00 | 520,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 293,000.00 | 520,000.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 293,000.00 | 520,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 293,000.00 | 520,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 764,761,100.00 | 1,028,582,700.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 660,198,700.00 | 914,409,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 660,198,700.00 | 914,409,100.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 104,562,400.00 | 114,173,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 104,562,400.00 | 114,173,600.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II) | 721,205,356.18 | 962,829,427.77 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 721,205,356.18 | 962,829,427.77 |
| 210 | БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 705,355,836.18 | 950,619,897.77 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 489,195,636.18 | 700,050,940.97 |
| 210101 | Үндсэн цалин | 343,220,326.18 | 425,505,574.97 |
| 210102 | Нэмэгдэл | 127,741,870.00 | 231,288,816.00 |
| 210104 | Үр дүнгийн урамшуулал | 18,233,440.00 | 43,256,550.00 |
| 2102 | Ажил олгочоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 64,425,300.00 | 87,759,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 43,808,800.00 | 59,676,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 5,153,600.00 | 7,020,900.00 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 4,123,800.00 | 3,510,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 1,031,000.00 | 3,510,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 10,308,100.00 | 14,041,300.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 100,562,400.00 | 110,173,600.00 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 6,711,518.18 | 6,807,658.17 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 93,137,453.41 | 102,458,741.83 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 713,428.41 | 907,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2105 | Нормативт зардал | 34,321,700.00 | 22,878,917.00 |
| 210502 | Хоол, хүнс | 34,321,700.00 | 22,878,917.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,000,000.00 | 4,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,000,000.00 | 4,000,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,810,800.00 | 6,438,699.80 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 175,000.00 | 520,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,635,800.00 | 5,918,699.80 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,040,000.00 | 19,318,340.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,570,600.00 | 16,981,940.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх | 2,469,400.00 | 2,336,400.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 15,849,520.00 | 12,209,530.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 15,849,520.00 | 12,209,530.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал | 13,709,420.00 | 10,961,530.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 2,140,100.00 | 1,248,000.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 43,848,743.82 | 66,273,272.23 |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 14,700,000.00 | 24,618,800.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 14,700,000.00 | 24,618,800.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 14,700,000.00 | 24,618,800.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 14,700,000.00 | 24,618,800.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (14,700,000.00) | (24,618,800.00) |
| | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 29,148,743.82 | 41,654,472.23 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 7,095,857.94 | 36,244,601.76 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 36,244,601.76 | 77,899,073.99 |

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

## ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Őóãàõàà: 24.12.31

| | ҮЗҮҮЛЭЛТ | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 0 | ДАНС | 511 | 51300 | 51210+51220 | |
| 2 | 2023 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл | 445813001.30 | 416394975.77 | -210766596.89 | 651441380.18 |
| 3 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0 | 0 | 0 | 0 |
| 4 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 445813001.30 | 416394975.77 | -210766596.89 | 651441380.18 |
| 8 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | 0 | 0 | -40944284.08 | -40944284.09 |
| 9 | 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 445813001.30 | 214672236.77 | 317529554.56 | 978014792.63 |
| 10 | 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 445813001.30 | 214672236.77 | 317529554.56 | 978014792.63 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 11 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0 | 0 | 832344 | 832344 |
| 12 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 445813001.30 | 214672236.77 | 318361898.56 | 978847136.63 |
| 13 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0 | -832344 | 0 | -832344 |
| 17 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | 0. | 0 | 54689616.43 | 54689616.44 |
| 18 | 2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 445813001.30 | 213839892.77 | 373051514.99 | 1032704409.07 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Õóãàöàà: 24.12.31

| ДАНС | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | - | - |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 951,187,800.00 | 873,274,627.77 | 77,913,172.23 | 91.81 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 951,187,800.00 | 873,274,627.77 | 77,913,172.23 | 91.81 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 938,142,800.00 | 861,065,097.77 | 77,077,702.23 | 91.78 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 761,143,700.00 | 700,050,940.97 | 61,092,759.03 | 91.97 |
| 210101 | Үндсэн цалин | 559,853,900.00 | 425,505,574.97 | 134,348,325.03 | 76.00 |
| 210102 | Нэмэгдэл | 181,626,200.00 | 231,288,816.00 | (49,662,616.00) | 127.34 |
| 210104 | Урамшуулал | 19,663,600.00 | 43,256,550.00 | (23,592,950.00) | 219.98 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 95,143,100.00 | 87,759,400.00 | 7,383,700.00 | 92.24 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 64,697,300.00 | 59,676,600.00 | 5,020,700.00 | 92.24 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,611,400.00 | 7,020,900.00 | 590,500.00 | 92.24 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 3,805,800.00 | 3,510,300.00 | 295,500.00 | 92.24 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,805,800.00 | 3,510,300.00 | 295,500.00 | 92.24 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,222,800.00 | 14,041,300.00 | 1,181,500.00 | 92.24 |
| 2105 | Нормативт зардал | 26,800,000.00 | 22,878,917.00 | 3,921,083.00 | 85.37 |
| 210502 | Хоол, хүнс | 26,800,000.00 | 22,878,917.00 | 3,921,083.00 | 85.37 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 6,638,300.00 | 6,438,699.80 | 199,600.20 | 96.99 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 520,000.00 | 520,000.00 | - | 100.00 |
| 210806 | Мэдээллийн технологийн зардал | 6,118,300.00 | 5,918,699.80 | 199,600.20 | 96.74 |
| 2201 | Бараа үйлчилгээний бусад зардал | 48,417,700.00 | 43,937,140.00 | 4,480,560.00 | 90.75 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 46,070,800.00 | 41,600,740.00 | 4,470,060.00 | 90.30 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,346,900.00 | 2,336,400.00 | 10,500.00 | 99.55 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 13,045,000.00 | 12,209,530.00 | 835,470.00 | 93.60 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 13,045,000.00 | 12,209,530.00 | 835,470.00 | 93.60 |
| 213205 | Тэрээс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг | 11,797,000.00 | 10,961,530.00 | 835,470.00 | 92.92 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 1,248,000.00 | 1,248,000.00 | - | 100.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 951,187,800.00 | 914,929,100.00 | 36,258,700.00 | 96.19 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 914,409,100.00 | 914,409,100.00 | - | 100.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 914,409,100.00 | 914,409,100.00 | - | 100.00 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 36,778,700.00 | 520,000.00 | 36,258,700.00 | 1.41 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 520,000.00 | 520,000.00 | - | 100.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 36,258,700.00 | - | 36,258,700.00 | - |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 36,244,601.76 | (36,244,601.76) | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 77,899,073.99 | (77,899,073.99) | - |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - | - | - |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | - | - | - | - |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 25.00 | 25.00 | - | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 16.00 | 19.00 | (3.00) | 118.75 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 8.00 | 5.00 | 3.00 | 62.50 |
| 63 | СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/ | - | - | - | - |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Õóâàöàà: 24.12.31

| ДАНС | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь | ДАНС |
|---|---|---|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | - | - | |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 114,173,600.00 | 114,173,600.00 | - | 100.00 | 2 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 114,173,600.00 | 114,173,600.00 | - | 100.00 | 21 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 114,173,600.00 | 114,173,600.00 | - | 100.00 | 210 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 110,173,600.00 | 110,173,600.00 | - | 100.00 | 2103 |
| 210301 | Гэрэл цахилгаан | 9,240,100.00 | 6,807,658.17 | 2,432,441.83 | 73.68 | 210301 |
| 210302 | Түлш, халаалт | 100,130,100.00 | 102,458,741.83 | (2,328,641.83) | 102.33 | 210302 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 803,400.00 | 907,200.00 | (103,800.00) | 112.92 | 210303 |
| 2106 | Эд хогшил худалдан авах | 4,000,000.00 | 4,000,000.00 | - | 100.00 | 2106 |
| 210604 | Урсгал засвар | 4,000,000.00 | 4,000,000.00 | - | 100.00 | 210604 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 114,173,600.00 | 114,173,600.00 | | - | 100.00 | |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 114,173,600.00 | 114,173,600.00 | | - | 100.00 | 1320 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 114,173,600.00 | 114,173,600.00 | | - | 100.00 | 132001 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 0.00 | (0.00) | | - | 4 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - | | - | - | 5 |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - | | - | - | 6 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | - | - | | - | - | 61 |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 25.00 | 25.00 | | - | 100.00 | 62 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | | - | 100.00 | 620001 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 16.00 | 19.00 | (3.00) | | 118.75 | 620002 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 8.00 | 5.00 | 3.00 | | 62.50 | 620003 |
| 63 | СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/ | - | - | | - | - | 63 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

**Алдархаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн *үйл ажиллагааны чиглэл:***

- *Бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх*

**Алдархаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн *зорилго:*** *Хүүхэд бүрийн сурах үйлийг дэмжин, бие даан суралцах, эрүүл зөв дадал хэвшилтэй суралцагч бэлтгэхэд оршино.*

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 33 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 28 арга хэмжээг хэрэгжүүлж 92 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

*Алдархаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:*

1. Боловсролын ерөнхий хууль
2. Төрийн хэмнэлтийн тухай хууль
3. Төрийн албаны тухай хууль
4. Төсвийн тухай хууль
5. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
6. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
7. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
8. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
9. Хөдөлмөрийн тухай хууль
10. Төрийн хэмнэлтийн тухай хууль
11. Шилэн дансны тухай хууль
12. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд орсон өөрчлөлт:

2024 оны 03 сарын 27-ны 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалйн цалингийн хэмжээг шинэчлэн тотоосон, Боловсролын ерөнхий хууль 2024 оны 07-р сарын 07-нд батлагдсан. Засгийн газрын 2024 оны 08 сарын 28-ны 53 дугаар тогтоолоор "Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр" шинэчлэгдэн батлагдсан, Сангийн Сайдын 2024 оны 04 сарын 01-ний А/52 тушаалаар дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн баталсан.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тушаалаар батлагдсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 1,3 "Аж ахуйн нэгж байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-тай байна гэсний дагуу байгууллагын дотоод хяналтын комиссыг 2024 оны 09 сарын 02-ны А/12 тушаалаар шинэчлэн 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Журмаа шинэчлэн боловсруулж улирал бүр төлөвлөгөө гарган хэрэгжилтийг тайлагнаж ажилладаг

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Дотоод хяналтын багийг байгуулж, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Мөн Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд Сургуулийн захирал, санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алдархаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Алдархаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 121,097.0 мянган төгрөгөөр буюу 89.5 хувиар өссөн байна.

***Хүснэгт 1.*** *Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Бараа материал | 122,487.6 | 12,1090.4 | -1,397.2 |

| | | | |
|---|---|---|---|
| Үндсэн хөрөнгө | 869,454.6 | 948,639.5 | 79,184.9 |
| **Нийт хөрөнгө** | **1,028,186.8** | **1,149,283.8** | **121,097.0** |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 445,813.0 | 445,813.0 | 0 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1,028,186.8** | **1,149,283.8** | **121,097.0** |

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

**Тайланд онд:**

Бараа материалын эхний үлдэгдэл 122,487.6 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 56,391.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 1,612.3 мянга хувь хүний хандиваар 725.0 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 60,125.8 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эцсийн үлдэгдэл 121,090.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,397.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 100,056.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хөрөнгө оруулалтаар 45,566.6 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, жилийн эцэст 79,184.9 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 66,437.8 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,065,361.4 мянган төгрөг, нийт зарлагыг мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл тодотголоор нэмж баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 914,409.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 114,173.6 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 987,448.2 мянган төгрөг буюу 92.7 хувьтай байна. Энэ нь цалин, ндш, хоол хүнс, бусад бараа материалын зардлыг 77,913.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

***Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл***

*/мянган төгрөгөөр/*

| Хөтөлбөр арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **Улсын төсвөөс санхүүжих** | | | | | |
| **71802** | **Ерөнхий боловсрол** | | | | |
| 80226 | Байр ашиглалтын үйлчилгээ | 627.10 | 480.00 | 147.10 | 77% |
| 80233 | Хүүхэд хамгаалал | 662.80 | 653.00 | 9.80 | 99% |
| 81605 | Эрүүл мэндийг дэмжих | 687.10 | 687.10 | 0.00 | 100% |
| 81806 | Дотуур байрны үйлчилгээ | 129,167.70 | 122,698.70 | 6,469.00 | 95% |
| 81816 | Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 35,539.40 | 32,938.80 | 2,600.60 | 93% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 81823 | Боловсролын байгууллагын багш ажилтны мэргэжил дээшлүүлэх | 1,728.00 | 200.00 | 1,528.00 | 11.8% |
| 81827 | Бичиг үсгийн боловсрол | 2,916.30 | 1,475.00 | 1,441.30 | 50.6% |
| 81834 | Боловсролын стандарт сургалтын орчин | 743,340.20 | 678,605.30 | 64,734.90 | 91.3% |
| 81835 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 22,475.50 | 22,475.50 | 0.00 | 100% |
| 80312 | Сургалт семинар | 500.80 | 500.00 | 0.80 | 100% |
| 81801 | Үдийн цай хөтөлбөр | 11,797.00 | 10,961.50 | 835.50 | 92.9% |
| 81848 | Сурах бичгийн түрээс | 520.00 | 520.00 | 0.00 | 100% |
| 81875 | Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх | 1,225.90 | 1,079.80 | 146.10 | 88% |
| **НИЙТ** | | **951,187.80** | **873,274.70** | 77,913.20 | **92.7%** |
| **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | | | | | |
| 80109 | ТЗШ-ийн байгууллагын тогтмол зардал | 114,173.60 | 114,173.60 | 0.00 | 100% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Нэмэлт байхгүй

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

Худалдан авах ажиллагааг тендер зарлаагүй сумын хүрээнд шууд гэрээ байгуулж ажилласан.

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Алдархаан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг "Хаан соёомбо аудит ХХК"-ны гэрээт аудитор Б.Цэрэндэжид гүйцэтгэж, анхан шатны хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсувд хийж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Алдархаан сумын ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 07 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг 1,022,317.0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 20,446.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 16,357.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 5 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Алдархаан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4,568.7 мянган төгрөгийн зөрчилд 1 заалт зөвлөмж, 4,568.7 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлэн ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 1 | 4,568.7 | 1 | 4,568.7 | 100% |
| **Нийт дүн** | **1** | **4,568.7** | **1** | **4568.7** | **100%** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хүүхдийн хоолны нормативыг мөрдөж ажиллах, амархан муудаж, чанар байдал нь алдагдах хүнсний бүтээгдэхүүнийг нөөцөлж, удаан хугацаагаар хадгалахгүй байх, эд хариуцагчийн гаргаж байгаа бараа материалын тайланг сар бүр хянаж, үлдэгдлийг баталгаажуулж байх

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 8,725.55 мянган төгрөгийн алдаа илэрч, 2,523.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

***Залруулсан алдаа:*** *Залруулсан алдаа байхгүй*

### 5.1 Төлбөрийн акт:

- ***Илэрсэн алдаа:*** Жилийн эцсийн тооллогоор хүнсний материалын үлдэгдэл 11 нэр төрлийн 2,523.1 мянган төгрөгийн хүнсний материал дутагдсан.

- ***Шийдвэрлэсэн нь:*** Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг тус тус зөрчсөнд 2,523.1 мянган төгрөгийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага: өгөгдөөгүй

### 5.3 Зөвлөмж:

***Илэрсэн алдаа:*** Хүүхдийн үдийн хоолыг нормативт зардлаас 659.4 мянган төгрөгөөр илүү, дотуур байрын хүүхдийн хоолны зардлыг нормативаас 852.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан.

**Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх" заалт, Засгийн газрын 2019 оны 450, 2024 оны 237 дугаар тогтоолуудыг хэрэгжүүлэн ажиллах

***Илэрсэн алдаа:*** Зардлыг эдийн засгийн ангиллаар зарцуулаагүй 2,987.5 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан.
**Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2.батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах; Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"ыг, батлагдсан төсвийн дагуу эдийн засгийн ангилалаар зардал гаргах, хууль, журмыг мөрдөж ажиллах, хяналтыг хэрэгжүүлэх

***Илэрсэн алдаа:*** Цалингийн зардлаас багш, ажилчдад шагналын дагалдах мөнгөн шагнал олгосон

**Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2.батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах; Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"ыг, батлагдсан төсвийн дагуу эдийн засгийн ангилалаар зардал гаргах, хууль, журмыг мөрдөж ажиллах, хяналтыг хэрэгжүүлэх

***Илэрсэн алдаа:*** Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 157 төрлийн 126,389.2 мянган төгрөгийн хөрөнгө элэгдээрээ анхны өртгөө нөхсөн үлдэгдэл өртөггүй хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***Өгсөн зөвлөмж:*** Дахин үнэлгээ хийх шалгуур хангасан хөрөнгөнд үнэлгээ хийж бүртгэлд тусгах, цаашид ашиглах боломжгүй хөрөнгүүдийг холбогдох газрын зөвшөөрлийн дагуу данснаас хасах арга хэмжээ авч, үндсэн хөрөнгийн бүртгэлийг цэгцлэх;

Энэхүү зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшингөөс бага байгаа тул "**Өөрчлөлтгүй**" дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Дотуур байрны хүүхдийн хоолыг нормативт зардлаас дутуу олгосон | 1 | 855.5 | | | | | 1 | 855.5 | | | | |
| Хүүхдийн Үдийн хоолыг нормативт зардлаас илүү олгосон | 1 | 659.4 | | | | | 1 | 659.4 | | | | |
| Жилийн эцсийн тооллогоор хүнсний материалын үлдэгдэл 11 нэр төрлийн гурил,сүү,тараг,гоймон,элсэн чихэр дутагдсан | 1 | 2,523.1 | 1 | 2,523.1 | | | | | | | | |
| Цалингийн зардлаас багш,ажилчдад боловсролын жуух бичиг,тэргүүний ажилтан дагалдах мөнгөн шагнал олгосон | 1 | 1,700.0 | | | | | 1 | 1,700.0 | | | | |
| Анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн 0 үлдэгдэлтэй байгаа 157 нэр төрлийн 126,389,216.00 төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж ашиглалтын хугацааг сунгах | | - | | | | | | - | | | | |
| Зардлыг эдийн засгийн ангиллаар зарцуулаагүй байна. | 1 | 2,987.5 | | | | | 1 | 2,987.5 | | | | |
| **Дүн** | | **8,725.5** | | 2,523.1 | | | | **6,202.4** | | | | |

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

**ХЯНАСАН:**

АХЛАХ АУДИТОР Ц.ОЮУНСУВД

АУДИТЫН МЕНЕЖЕР: Х.БОЛДБААТАР

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

Огноо: 2025-02-14

**БОЛОВСРУУЛСАН:**

"ХААН СОЁМО АУДИТ" ХХК ГЭРЭЭТ АУДИТОР Б.ЦЭРЭНДЭЖИД

Огноо: 2025-02-14